

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны чиг үүрэг, бүрэн эрх, хурлын зохион байгуулалт, ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

### Хоёр. Нэр дэвшүүлэх хорооны чиг үүрэг, бүрэн эрх

- 2.1. Нэр дэвшүүлэх хорооны чиг үүрэг
- 2.1.1. ТУЗ-ийн залгамж халааны тогтвортой байдлыг хангах хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- ТУЗ-ийн залгамж халааны бодлогыг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг боловсруулж ТУЗ-өөр батлуулах;
  - ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, боловсрол, ажлын туршлага, ур чадвар, хувь хүний зан чанарын болон хараат бус байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, тус шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу нээлттэй зарлах замаар ил тод явуулан, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг бүртгэн, урьдчилсан байдлаар үнэлж, хараат бус гишүүний хувьд холбогдох хууль болон компанийн холбогдох журам, бодлогын баримт бичигт заасны дагуу хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, ХЭХ-д нэр дэвшүүлэх;
  - Компанийн хувьцаа эзэмшигчийн зүгээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал оруулсан тохиолдолд холбогдох хууль, Компанийн холбогдох журам, бодлогын баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангаж байгаа байдлыг үнэлэн, ХЭХ-аар хэлэлцэх асуудалд оруулах эсэх, нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг шийдэж, хувьцаа эзэмшигчид тайлбарыг хүргүүлэх;

- ТУЗ-ийн гишүүнд шаардлагатай мэдлэг, ур чадвар болон сургалтын хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийг сургах мэргэшүүлэх ажлыг хариуцах;
- ТУЗ-ийн гишүүдийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон Санамж бичиг болон нууц хадгалах гэрээний агуулгыг тодорхойлон батлах;

## 2.2. Нэр дэвшүүлэх хорооны эрх мэдэл

2.2.1. Нэр дэвшүүлэх хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой дараах эрхтэй байна. Үүнд:

- ТУЗ-ийн залгамж халааны бодлого болон түүний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмуудыг тодорхойлон, ТУЗ-өөр батлуулах, түүнийг хэрэгжүүлэх талаар ТУЗ-д санал зөвлөмж өгөх;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон үалгаруулах үйл ажиллагаатай холбогдуулан шаардлагатай тохиолдолд гаднын зөвлөх үйлчилгээ, хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүд, хуульчдын зөвлөгөө, туслалцааг авах, тодорхой асуудлын хүрээнд хөлсөөр ажиллуулах;
- ТУЗ-ийн гишүүдийн жилийн үйл ажиллагааны талаар тайлан, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх саналыг ТУЗ-д оруулах;
- ТУЗ-ийн гишүүнтэй холбоотой шүгэл үлээх системээр ирсэн зөрчлийг хүлээн авах, шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт баталгаажуулалт хийлгэх хүсэлтийг дотоод аудиторт гаргах, зөрчлийн талаар ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх;
- Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг саадгүй гаргуулахаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хандах;
- Хууль тогтоомжид заасан болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргах.

### **Гурав. Нэр дэвшүүлэх хорооны хурлын зохион байгуулалт**

- 3.1. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байх бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус байж болно.
- 3.2. Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулна.

- 3.3. Нэр дэвшүүлэх хорооны ээлжит бус хурлыг Хорооны дарга, гишүүд, Компанийн хувьцаа эзэмшигчийн санаачилга, шаардлагаар хуралдуулж болно.
- 3.4. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь хорооны ээлжит хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлыг хурал хуралдахаас ажлын 10 (арав)-аас доошгүй хоногийн өмнө тодорхойлох бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хорооны гишүүдэд мэдээллийг хүргэнэ.
- 3.5. Нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн зүгээс хурлаар хэлэлцэх асуудалд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хурал хуралдахаас ажлын 5 (тав)-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн даргад саналаа бичгээр эсвэл и-мэйлээр хүргүүлж болно. Ингэхдээ хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах болсон шалтгаан, асуудлын томъёолол зэргийг тодорхой тусгасан байна.
- 3.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг холбогдох удирдлагуудаар бэлтгүүлэн, ажлын 3 (гурав)-аас доошгүй хоногийн өмнө хорооны гишүүдэд и-мэйлээр хүргүүлнэ.
- 3.7. Нэр дэвшүүлэх хорооны ээлжит бус хурал хуралдуулах санал гаргагч этгээд нь саналаа бичгээр эсвэл и-мэйлээр мэдэгдэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хамтран хурлын бэлтгэлийг хангана.
- 3.8. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахын тулд Компанийн удирдлагууд болон холбогдох нэгжийн ажилтнууд, гаднын зөвлөгчийг зөвхөн тус Нэр дэвшүүлэх хорооны хүсэлтээр оролцуулж болно.
- 3.9. Нэр дэвшүүлэх хорооны гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг гишүүд харилцан бие биеэ сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэлбэрээр буюу мэдээлэл харилцаа холбооны техник хэрэгсэл ашиглан зохион байгуулна.
- 3.10. Нэр дэвшүүлэх хорооны хуралд бүх гишүүд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 3.11. Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэхээр товлоогүй боловч тооцоо судалгаа шаардахгүй асуудлыг гишүүдийн дийлэнх олонх буюу гуравны хоёр нь зөвшөөрснөөр авч хэлэлцэж болно.
- 3.12. Нэр дэвшүүлэх хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд тэмдэглэлийг Хорооны дарга хянан, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

- 3.13. Нэр дэвшүүлэх хорооны хурлаар асуудал шийдвэрлэхэд хорооны гишүүн бүр саналын нэг эрхтэй ба гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 3.14. Нэр дэвшүүлэх хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцолгүйгээр урьдчилан санал өгсөн тохиолдолд тухайн саналыг санал өгсөнд тооцон шийдвэр гаргана.
- 3.15. Нэр дэвшүүлэх хороо нь өөрийн тогтоолын хэвлэмэл хуудастай байна.
- 3.16. Нэр дэвшүүлэх хорооны хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд уг шийдвэрийг зөвшөөрсөн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.17. Нэр дэвшүүлэх хороо нь хурлаар хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, санал зөвлөмж, үүрэг даалгавар, удирдамж гаргана.

#### **Дөрөв. Жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө**

- 4.1. Нэр дэвшүүлэх хороо тухайн жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт болон жилийн үйл ажиллагааны тайланг жилийн эцэст хэлэлцэн дүгнэх ба эцсийн тайланг ТУЗ-ийн нарийн бичиг бэлтгэж хорооны даргаар хянуулна.
- 4.2. Нэр дэвшүүлэх хорооны жилийн үйл ажиллагааны тайланд хорооны хурлын давтамж, ирц, хэлэлцсэн асуудал, тухайн жилд хийж гүйцэтгэсэн онцлох ажил, үр дүнгийн мэдээллийг оруулна.
- 4.3. Нэр дэвшүүлэх хороо ирэх жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэн боловсруулах ба төлөвлөгөөг оны эхний ТУЗ-ийн хурал дээр хороон дарга танилцуулж ТУЗ-ийн даргаар батлуулна.
- 4.4. Нэр дэвшүүлэх хороо нь жил бүр Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд Хорооны жилийн тайланг тусгах ба Компанийн цахим хуудсанд нэр дэвшүүлэх бодлогын баримт бичиг болон ажлын үр дүнгээ тайлагнан мэдээлнэ.
- 4.5. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр жилийн ажлын тайлангаа биечлэн тайлагнана.

#### **Тав. ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа**

- 5.1. Компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх Удирдлага ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй байна.
- 5.2. ТУЗ-ийн гишүүний ор гарсан, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн тохиолдолд Нэр дэвшүүлэх Хороо сонгон шалгаруулалтад нэр

дэвшүүлэх зарыг 14 хоногийн хугацаатай нэр дэвшүүлэх эрх бүхий этгээдүүдэд хүргүүлж, компанийн албан веб хуудсанд байршуулна.

- 5.3. Сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэх зард дараахи мэдээллийг тодорхой тусгана:
- ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлт
  - Материал хүлээн авах хаяг, хугацаа, холбоо барих мэдээлэл
  - ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшигчийн анкет
- 5.4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах, сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх, материалын бүрдлийг хангах, Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэх бэлтгэлийг хангана.
- 5.5. ТУЗ-ийн хараат бус Гишүүнд нэр дэвшигчээс дараахи баримт бичгийг хүлээн авна:
- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл
  - ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшигчийн анкет
  - Хараат бус Гишүүний шаардлагыг хангаж байгаа эсэх өөрийн нь баталгаа бичиг
  - Ажил байдлын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэхийн хуулбар
  - Боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээний хуулбар
  - Компанийн Засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар
  - Оршин суугаа газрын тодорхойлолт
  - Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
- 5.6. Компанийн албан веб хуудсаар ирүүлсэн нэр дэвшигчийн материалыг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй этгээдүүдэд тухай бүр хүргүүлнэ.
- 5.7. Нэр дэвшүүлэх эрх бүхий этгээдүүдээс нэр дэвшүүлсэн этгээдүүдийн материалыг Нэр дэвшүүлэх Хороо 14 хоногийн хугацаанд хэлэлцэн тохиромжтой гэж үзсэн 2-оос доошгүй нэр дэвшигч бүхий жагсаалт, мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.
- 5.8. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тухай бүр СЗХ болон Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, мэдээллийг

Компанийн цахим хуудаст байршуулж, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангана.

- 5.9. Нэр дэвшүүлэх Хороо нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүнийг ажил үүрэгт нь чиглүүлэх сургалтыг Гишүүн сонгогдсноос хойш 14 хоногийн дотор зохион байгуулна.

**Зургаа. ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур**

- 6.1. ТУЗ-ийн Гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур нь:

- 6.1.1. Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадвартай, 18 ба түүнээс дээш настай байх;
- 6.1.2. Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх;
- 6.1.3. Тухайн цаг хугацаанд ял шийтгэл эдлээгүй, эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдээгүй байх;
- 6.1.4. Компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой биш, тэдгээрийн төрөл садан, гэр бүлийн гишүүн биш байх;
- 6.1.5. Компанитай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч байгууллагад ажил үүрэг хашдаггүй байх;
- 6.1.6. Бизнесийн удирдлагын туршлагатай байх;
- 6.1.7. Санхүү, эдийн засгийн суурь мэдлэгтэй байх;
- 6.1.8. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;
- 6.1.9. Ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх.

- 6.2. ТУЗ-ийн хараат бус Гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур нь:

- 6.2.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх;
- 6.2.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь Компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх;
- 6.2.3. Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх.

**Долоо. Хяналт, хариуцлага, ил тод байдал**

- 7.1. Нэр дэвшүүлэх хороо нь явагдсан сонгон шалгаруулалтын явц, үр дүнгийн тайланг тухай бүр бичиж хадгална.

\*\*\*







# One Partners